

МОНГОЛ-ОРОСЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР

Б. Эрдэнэбат*

Монгол-Оросын хооронд үүсч тогтсон харилцааны түүх олон зуун дамжсан баялаг уламжлалтай хэдий боловч өнгөрөгч ХХ зуунд явагдаж байсан харилцаа, хамтын ажиллагаа арай өвөрмөц, илүү ойртож нягтарсан, хоёр орны эрх ашиг, сонирхол олон талаар нийцсэн, мөн хоёр орон хамтран ажиллахаас өөр аргагүй нөхцөл байдал тулгарсан цаг үе байснаар онцлог юм.

Үүнтэй уялдуулж, өнөөдрийн энэ арга хэмжээний үндсэн сэдэв болох “Монгол Улс, ОХУ-ын харилцаа: түүх ба орчин үе”-ийн өнөөгийн байр сууринаас харахад, хоёр орны цэргийн харилцааг он цагийн болон шинж чанарын байдлаар дараах хэд хэдэн үе шатанд хувааж үзэж болохоор байдаг. Үүнд,

- 1911-1921.VII хүртлэх үе. Өөрөөр хэлбэл цагаагчин гахай жилийн хувьсгалын үр дүнд монголчууд харийн ноёрхлыг түлхэн унагаж туурга тусгаар улсаа байгуулсан тэр цаг үеэс монгол-оросын цэргийн харилцааны үндэс тавигдсан гэж болох юм.”

Чухам энэ үе шатанд Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийг хаант Оросын зүгээс дэмжиж үндэсний цэрэгтэй болоход нь бодитой тусламж үзүүлсэн байдгийг түүхэн баримтууд гэрчилдэг. Хэд хэдэн удаагийн хэлэлцээрийн дүнд оросоос монголд зэр зэвсэг, санхүүгийн тусламж үзүүлэхийн сацуу сургагч нарыг ирүүлж байжээ.

Харамсалтай нь энэ үе шатны дундуур Оросын болон Дундад иргэн улсын их гүрнүүдийн дээрэнгүй бодлогын уршгаар “Хиагтын 3 улсын хэлэлцээр” гээчийг байгуулснаар Монголын тусгаар тогтнол цуцлагдаж автономит эрхтэй үлдэж байв. Тэгээд ч ядарч доройтоод байсан Монголыг хэсэглэн хувааж захирах (*“divide and rule” гэдгийн сонгомол жишээ*) шалтаг боломжийг их гүрнүүд овжин ашигласан нь эдүгээ монгол туургатан, угсаатан ястны хувьд 3 тасарсан бодит үнэний илрэл болно.

Ер нь 1768-1961 оны хооронд буюу 200 шахам жилийн туршид монгол цэргийн талаар болон монгол-оросын цэргийн харилцааны холбогдолтой, орос хэл дээр хэвлэгдсэн 5070 гаруй нэрийн ном өгүүллэг байдаг. Гэхдээ XIX зууны төгсгөлд оросын талаас монголын

* Б.Эрдэнэбат - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого судлалын төвийн дарга, техникийн шинжлэх ухааны доктор, хошууч генерал

** Монгол-Оросын цэргийн харилцаанд нэг талыг баримтлаж Оросын талаас Монголыг судлан тандаж байсан цаг үе өөрчлөгдөж хоёр талын ашигтай харилцаа эхлэсэн гэсэн санааг агуулж байгаа юм.

газар орны байдал (*военная топография гэсэн утгаар*), ёс заншил, байгалийн баялаг зэрэгтэй холбогдох олон чиглэлд судалгааны ажил явуулж байсан нь цэрэг-стратегийн зорилгод нийцүүлж явуулсан цэргийн тагнуулын арга хэмжээ гэж дүгнэх бүрэн үндэстэй юм. Энд ганцхан жишээ болгож, оросын армийн штабын ажилтан (*штабс-капитан*) Н.М.Прежевальскийн ахласан баг төв Азиар аялсан 2 дахь экспедицийн материалыг (*1976 онд Санкт-Петербург хотноо хэвлүүлсэн “Монголия и страна Тангутов” гэдэг гурван боть ном*) дурдахад хангалттай байх биз.

Монголчууд эрх чөлөөгөө алдсан хэдий боловч оросын цагаантны томоохон хүчний оролцоотойгоор хятадын гамин цэргийг нутгаасаа хөөж зайлуулсан, автономийг сэргээсэн гэх мэт сонин тохиолдлууд энэ үе шатанд болж байсан нь хоёр орны цэргийн харилцааны бас нэгэн хэсэг гэлтэй.

- 1921.VII - 1936.III. Хөрш хоёр орны гадаад дотоод улс төрийн байдлаас үүдэж тасалдангуй байсан албан ёсны харилцааг сэргээх шаардлага тулгарсан нөхцөлд энэ үе шатны эхлэл тавигдсан ба 1921 оны ардын хувьсгалын өрнөл, ялалтын явцад өргөжиж дараах арваад жилд нь тодорхой чиглэлд, янз бүрийн байдлаар хэрэгжсэн байдаг.

Энэ үе шатанд ЗХУ-аас Монголд зэвсгийн, санхүүгийн тусламж үзүүлэхийн дээр цэргийн тусламж үзүүлж ирсэн бөгөөд хоёр орон, “нэг онол, нэгдмэл үзэл суртал”-аар холбогдож байсан нь цэргийн харилцааны гол шинж чанарыг илэрхийлэхийн зэрэгцээ олон улсын байдал төвөг бэрхшээл ихтэй байснаас болж харилцан туслах арга замыг сонгосон гэж болно. Энэ үе шатанд харилцааны хувьд өмнөх үеэсээ багагүй зүйлийг уламжлан хэрэгжүүлж ирсний сацуу шинэ хэлбэр болох “хувьсгалт” гэдэг ойлголтонд хамаарах бүхий л санааг агуулж байсан онцлогтой байв.

- 1936.III-1945.IX. Энэ цаг үе бол БНМАУ-ын хувьд төвөгтэй бөгөөд дэлхийн II дайны хүнд бэрх жилүүд давхцсан үе байлаа. Энэ үе шатанд БНМАУ, өөрийн аюулгүй байдлыг хамгаалахдаа оросын тусламжинд тулгуурлах бодлого баримтлаж ЗХУ-ын цэргийг нутагтаа байрлуулсан,

Тэгээд ч 1939, 1945 оны дайнд хоёр орны армиуд мөр зэрэгцэн оролцсон зэрэг онцлог үйл явдлууд болж өнгөрсөн. Энэ үеийн хамгийн чухал ач холбогдол гэвэл ЗХУ-ын Алс дорнотын аюулгүй байдлыг хангаснаар БНМАУ-ын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бэхжүүлсэнд оршино. Энд тодруулж хэлэхэд, хоёр орны батлан хамгаалах салбарт төдийгүй Монгол Улс тусгаар тогтнолоо хамгаалж үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн нэг үйл явдал гэвэл 1936 онд хоёр орны хооронд байгуулагдсан “Харилцан тусалцах тухай протокол” бөгөөд үүнтэй холбогдуулж И.Сталин, В.Молотов нарын хийж байсан мэдэгдэлд

“...хэрэв японы зүгээс Монголд халдан довтолбол 1921 онд тусласан шигээ дахин туслахад бэлэн. БНМАУ-ын хил хязгаарыг өөрийн хилийг хамгаалахтай адил шийдвэртэйгээр хамгаална...” гэсэн онц хурц санаа байсан юм. Энэ бол хоёр орны цэргийн харилцаа холбоотны төвшинд хүрснийг бас дам харуулж байгаа юм.

- 1946-1960 оны дунд үе. Энэ үе шат нь дэлхийд социалист систем тогтсон, хүйтэн дайн эхлэсэн, Монголд энхийн цагийн бүтээн байгуулалт өрнөж байсантай уялдаж хоёр орны цэргийн харилцаа цэрэг зэвсэг гэхээс илүүтэйгээр боловсон хүчин бэлтгэх хэлбэрээр явагдаж байв.

Сонирхуулж хэлэхэд, монгол цэргийн дарга нарыг Зөвлөлтийн цэргийн сургуульд 1921 оноос анхлан явуулж эхлэсэн бөгөөд зарим тоо баримтаас дурдвал, 1921 онд анхны 4 хүн цэргийн сургуульд явж байсан бол 1946-1960 оны хооронд нийтдээ 399 хүн зөвлөлтийн цэргийн сургуульд суралцсан байдаг.

- 1960-1980 оны сүүлч үе. Энэ үеийг хоёр орны цэргийн харилцааны оргил үе гэж болох юм. Зөвлөлт, Хятадын харилцаа өнгөрөгч зууны 60-аад оны дундаас эрс хурцадсан явдал, улмаар Монгол-Оросын цэргийн харилцааг “хятадын цэргийн аюулаас хамгаалах” зорилго бүхий холбоотны төвшинд хүргэх шалтаг болов. Энэ нь, Монголын геополитикийн орчин, геостратегийн байршлаас үүдэж Монгол-Зөвлөлтийн хамтын батлан хамгаалах бодлогын үр дагавар байдлаар илэрч бүс нутгийн утга агуулгатай болсон. 1964 оноос эхлэсэн батлан хамгаалах салбарыг өргөтгөн зохион байгуулах асуудал тасралтгүй хэрэгжиж ирснээр чухам энэ үе шатанд МАА-ийн бүтэц, бүрэлдэхүүн эрс шинэчлэгдсэн хэлбэртэй болж бие бүрэлдэхүүний нөхөн хангалт урьд хожид байгаагүй хэмжээнд хүрч өргөжсөн билээ.

Хоёр орны цэргийн харилцаа, дахин холбоотны төвшинд хүрч шаардлага тулгарсан тохиолдолд нэг фронтод (*Өвөр байгалийн цэргийн тойрогт*) нэгдэж байлдааны ажиллагаа явуулах асуудлыг боловсруулж байв.

Мөн энэ үед МАА-ийн нэгтгэл, анги, салбаруудад Зөвлөлтийн сүүлийн үеийн хийц загварын зэвсэг, байлдааны болон хангалтын техникийг маш олон тоогоор буцалтгүй тусламжаар нийлүүлсэн төдийгүй ялангуяа энэ үе шатны сүүлийн 10-аад жилд зөвлөлтийн цэргийн зөвлөх мэргэжилтнүүд монголд олноор ажиллаж байлаа.

- 1990 оноос өнөөг хүртлэх үеийн байдлыг ерөнхийд нь нэгтгэн авч үзэж болох юм. Өнгөрөгч зууны 90-ээд оноос дэлхий даяар геополитикийн нөхцөл байдал үндсээрээ солигдож даярших агуулгатай цөөнгүй өөрчлөлт явагдаж эхлэсэн нь монгол-оросын цэргийн харилцаанд төдийгүй ерөөсөө хоёр орны харилцаанд олон талт байдлаар нөлөөлсөн.

ЗХУ задрахын сацуу хуучин социалист гэгдэж байсан улс орнууд, тэр дундаа Монгол Улс өөрчлөгдөж буй ертөнцөд өөрийн гэсэн улс

төрийн байр суурийг олох гэж ардчилсан шинэчлэлт, зах зээлийн эдийн засаг уруу шилжих явцыг өрнүүлж эхлэв. Ингэснээр үзэл сурталд тулгуурлаж байсан Монгол-Оросын цэргийн харилцаа, шинэ зарчимд орж эдүгээ хэн хэнийхээ үндэсний эрх ашиг, нийгмийн сонирхлыг харгалзан үзсэн хөгжлийн шатанд орж байна.

Түүхийн хуудсыг эргэн сөхөж харваас, зөвлөлтийн армийн нэгтгэл ангиуд Монголд гурван удаа ирж нийтдээ 40 гаруй жил байрласан байдаг.

- 1921 онд зөвлөлтийн “Аялан байлдах корпус” ирж байрлаж байгаад хятадын зүгээс хийсэн удаа дараагийн шахалтаар Улаанбаатарт нэг морьт дивизион үлдээгээд гарсан байдаг.

- дараа нь 1936 оны эхээр манай талын хүсэлтээр Зөвлөлтийн цэргийн motoхуягт тусгай хороо Баянтүмэнд, motoхуягт бригад Өндөрхаанд ирж байрласан. Харин 1937 оны наймдугаар сарын сүүлчээр Улаан армийн ихээхэн хүч БНМАУ-ын нутагт ирж байрласан нь манай засгийн газартай зөвшилцөөгүй асуудал байсан бөгөөд улмаар их хэлмэгдүүлэлтийн эхлэл болсон юм.

- төгсгөлд нь, 1966 оны нэгдүгээр сард хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу Зөвлөлтийн 39 дүгээр арми (*зэвсэглэл, хуч бүрэлдэхүүний хувьд энэ арми нь Афганистанд байлдаж байсан Зөвлөлтийн 40 дүгээр армийн дараа орох хэмжээнд байсан*) Монголын нутагт ирж Улаанбаатар хот болон 15 аймаг, 64 сумын нутагт тархаж байрласан. Харин тус армийг Монголын нутгаас бүрэн гарч дууссан тухай 1992 оны 12 дугаар сарын 30-нд дэлхий нийтэд зарласан байдаг.

Гэвч, Зөвлөлтийн цэргийг Монголын нутагт оруулж ирэх, мөн манай нутгаас гаргах болсон шалтгаан бүр нь тухайн үеийн олон улсын байдал, монгол-оросын цэргийн харилцааны хөгжлийн хандлага, ЗХУ, БНХАУ, Япон зэрэг их гүрнүүдийн улс төрийн бодлого, цэрэг-стратегийн зорилготой нягт уялдаатай байсан нь мэдээж хэрэг билээ.

Монгол-Оросын батлан хамгаалах салбарын харилцааны талаар ярихад хамгийн их жин дарах хэсэг нь Монголд зэвсэг, байлдааны болон хангалтын техник нийлүүлэлтийн асуудал байдаг бөгөөд үүн дээр өнгөрөгч зууны 70-аад оны үед ихээхэн өргөжсөн байсан боловсон хүчин бэлтгэх асуудал нэмэгдэж ирэх юм.

Одоо Монголын зэвсэгт хүчний нөхөн хангалтанд байгаа зэвсэг, байлдааны техникийн дийлэнх хэсэг нь ЗХУ, ОХУ-д үйлдвэрлэгдсэн байдаг. Үүний наад захын жишээ болгож, манай зэвсэгт хүчний зэвсэглэлд 2010 онд, ОХУ-аас “Печора-2М” загварын зенитийн пуужингийн шинэ цогцолбор хүлээж авсныг хэлж болно.

Оросууд энэ цогцолбороо 2000 оноос туршиж эхлэсэн бөгөөд 2003 оноос гадаад зах зээлд нийлүүлж байгаа юм. Үүнийг авч эзэмшсэнээр

бид нам болон дунд өндрийн аливаа нисдэг биетийг илрүүлж устгах зориулалт бүхий орчин үеийн зэвсэгтэй боллоо, гэсэн үг.

Ер нь зэвсэг, техникийн шинэчлэлийн хүрээнд Монголд сүүлийн хоёр жилд дорвитой ахиц гарсан. Зарим нэг баримтыг хэлж болно. Монгол Улсын батлан хамгаалах салбар 2007-2008 онд гаднаас нийтдээ 14 тэрбум төгрөгийн тусламж авч байсан бол 2009-2010 онд тэр үзүүлэлт 125 тэрбум төгрөгт хүрч нэмэгдсэн юм. Мэдээж хэрэг энэ их тоон үзүүлэлтийн илт давуу хувийг ОХУ-тай хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны үр дүн эзлэнэ.

Үүний үлэмж хэсэг нь зэвсэг, байлдааны техникийн шинэчлэлд зориулагдсан бөгөөд харьцангуй орчин үеийн загварын Т-72А танк, БТР-70, БТР-80 маркийн дугуйт хуягт тээвэрлэгч, байлдааны болон тээврийн зориулалттай МИ-171 нисдэг тэрэг зэргийг дурдаж болох байна.

Үүний зэрэгцээ цэрэг-техникийн хамтын ажиллагаа, оператив-тактикийн төвшинд явуулж буй хамтарсан хээрийн сургууль дадлагыг хэлэх нь зүйтэй. Учир нь, аливаа улс орнуудын цэргийн хамтын ажиллагааны чухал үе шат, харилцан итгэлцлийн төвшин өндөр болж байгааг харуулах нэг үзүүлэлт бол хамтарсан хээрийн сургууль гэж үздэг.

Энд би зөвхөн сүүлийн 3 жилийн хугацаанд явагдсан хамтарсан сургууль дадлагад оролцсон анги салбар, хүн хүчний тоогоор өргөн хүрээнд болсон заримыг дурдвал,

- 2008 оны 11 дүгээр сард “Дархан-1”, 2009 оны 8 дугаар сард “Дархан-2” нэрийн дор явагдсан хамтарсан хээрийн сургуулийг Монголын нутаг дэвсгэрт,

- 2010 оны 9 дүгээр сард мөн ийм төвшний “Дархан-3” сургуулийг ОХУ-ын нутаг дэвсгэрт тус тус амжилттай зохион байгуулсан.

- хамгийн сүүлд 2011 оны 9 дүгээр сарын 01-15-нд Монгол-Оросын Зэвсэгт хүчний байлдааны болон хангалтын зарим ангиуд хамтарсан “Сэлэнгэ-2011” хээрийн сургуулийг манай Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн байрлалд буюу “Таван толгойн” районд зохион байгуулсан.

Монгол-Оросын цэргийн харилцааны тухай товчлон өгүүлсэн энэ сэдвийг хөндөхдөө ямар дүгнэлт хийж болох вэ?

- Монгол Улс, Манжийн эрхшээлээс ангижирч тусгаар тогтнолоо тунхаглахын сацуу хойт хөрш Орос улстай харилцаа тогтоож тусламж авах болсноор хоёр орны цэргийн харилцааны эхлэл тавигдсан.
- Монгол-Оросын цэргийн харилцаа өндөр төвшинд, нягт байсан нь нийгмийн бусад салбарт ч тодорхой нөлөөлж, манай орны нэр хүнд дээшлэхэд тухайн үедээ эерэг үр дагавар авчирсан, гэж болно.

- Монгол-Оросын цэргийн харилцаа нь 1921-1990 оны хугацаанд найрамдалт, ах дүүгийн гэсэн тодотголтой байсан боловч тэр нь улс төржсөн шинжтэй байв. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн Орос, Хятадын сөргөлдөөнт харилцаанаас улбаалж Монгол Улс нь үзэл суртал, эдийн засгийн талаар ЗХУ-ыг шууд дагаж улмаар түүнээс хараат болж хувирсан гэхэд хилсдэхгүй ба цэргийн харилцаанд бас нөлөө үзүүлсэн байна.
- Монгол Улсын Зэвсэгт хүчин өнгөрөгч 90 жилийн хугацаанд Зөвлөлтийн зэвсэг техникээр бараг дагнан хангагдаж ирсэн нь цэргийн ажиллагааны хувьд нэг орны туршлагад хэт дагнан тулгуурласан шинжтэй байв. Харин сүүлийн жилүүдэд НҮБ-ын мандат дор олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа нь манай цэргийн шинэчлэл цаашид шинэ хэлбэр агуулгаар баяжихад тус дөхөм болно гэж үзнэ.
- Монголын нутагт байрлаж байсан Зөвлөлтийн армийн цэргийн ангиудын ажиллагаанаас үүдэлтэй байгаль, экологийн хор хохирлын асуудал болон Оросын талын өмч хэвээр байгаа зарим барилга байгууламжийн талаар үл ойлголцол нэг тийш болоогүй өнөөг хүрсэн нь хоёр талын харилцааг улам үр дүнтэй болгоход их бага хэмжээгээр боловч тогтор болж байна.

Монгол-Оросын цэргийн харилцаа өнгөрөгч зууны 90-ээд оноос зогсонги байдалд орсон хэдий боловч талууд сүүлийн жилүүдэд энэ бэрхшээлийг даван туулж даяаршлын эрин үед нийтлэг зарчимд түшиглэж, шинэ хэлбэрээр хөгжих арга замыг эрэлхийлж байгаа билээ. Үүнд, бид Монгол орны мөнхийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж асуудалд хандахыг урьтал болгож байгаа болно.